



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 04

Даланзадгад

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1.2 "ж", 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулж, Төлөөлөгчийн үйл ажиллагаагаараа манлайлсан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Оны шилдэг Төлөөлөгч" шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж "Оны шилдэг Төлөөлөгч"-ийг нийтэд зарлан, алдаршуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Б.Галхүү/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Х.СУГИР





**Аймгийн ИТХ-ын "Оны шилдэг Төлөөлөгч"  
шалгаруулах журам**

**Нэг: Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид Хурал гэх/-ын Төлөөлөгчид, Тэргүүлэгчид бүрэн эрхээ хэрэгжүүлэх, сонгогдсон тойрогтоо ажиллах боломжийг нэмэгдүүлэх, нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх, Төлөөлөгч, Тэргүүлэгчдийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, шилдэг тэргүүний, шинийг санаачлагч Төлөөлөгч, Тэргүүлэгчийн ажлын амжилтыг урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

**Хоёр: "Оны шилдэг Төлөөлөгч" шалгаруулахад баримтлах зарчим,  
шалгуур үзүүлэлт**

- 2.1. ИТХ-ын Хороодын ажилд идэвхи санаачлагатай оролцох
- 2.2. Багаар ажиллах олон нийтийн үүсэл санаачлагыг өрнүүлэн дэмжиж ажиллах
- 2.3. Тухайн жилд хийж, хэрэгжүүлэх ажлын хөтөлбөр төлөвлөгөө гарган ажиллах
- 2.4. Сонгогдсон тойргийн иргэдэд хүрч ажиллан, хууль, журам, аймгийн ИТХ-аас баталсан тогтоол шийдвэрийг сурталчилж, ажлаа тайлагнасан байх
- 2.5. Орон нутаг болон сонгогдсон тойрогтоо жилд 2-оос доошгүй бүтээлч ажил, асуудал санаачлан хийж хэрэгжүүлэх
- 2.6. "Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн суудлын мөнгө зарцуулах журам"-ын дагуу суудлын мөнгөө үр дүнтэй зарцуулж, зардлын тайлангаа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанд хугацаанд нь өгөх
- 2.7. Аймгийн ИТХ-аас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхитэй оролцож, ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, хороодын дарга нараас өгсөн зөвлөмж, чиглэлийг чанартай сайн биелүүлэх
- 2.8. Аймгийн ИТХ-ын хуралдаан болон Тэргүүлэгчдийн хуралд аймаг, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр болохуйц асуудал санаачлан хууль, журмын дагуу оруулан хэлэлцүүлэх
- 2.9. Аймгийн ИТХ-аас гаргасан тогтоол шийдвэрийн биелэлтийг хангуулах чиглэлээр хяналт тавьж ажиллах
- 2.10. Аймгийн Засаг даргын "Бид хамтдаа" үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн зорилтууд, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулахад оролцсон байдал
- 2.11. "Нутгийн удирдлага" сэтгүүлийг улирал бүр захиалж, тойрогтоо хэрэгжүүлсэн ажлаа сэтгүүлээр дамжуулан орон даяар сурталчилсан байх
- 2.12. Сонгогдсон тойргийнхоо иргэдээс гарсан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлүүлэх, хариу өгөх
- 2.13. Төлөөлөгчийн харилцааны соёл, манлайлал үлгэр дуурайлал
- 2.14. Хүүхэд залуучуудын эх оронч үзэл, зөв төлөвшилд оруулж буй хувь нэмэр
- 2.15. Улаан загалмайн болон бусад энэрэнгүй үйлсэд оролцсон байдал
- 2.16. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцсон байдал



2.17. Иргэдийн эрх чөлөө хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлын үр дүн

2.18. Аймгийн ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийн ажлын албанаас хүргүүлж байгаа чиглэл, албан тоот, мэдээлэл зэргийг хүлээн авах, хариу өгөх зэргээр эргэх холбоотой ажилласан байх

#### **Гурав: “Оны шилдэг Төлөөлөгч”-өөр шалгаруулж, урамшуулах**

3.1. Төлөөлөгч бүр энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан үзүүлэлт тус бүрээр дэлгэрэнгүй тайлан гаргаж дараа оны 01 дүгээр сарын 15-ний дотор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанд ирүүлнэ.

3.2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын алба тайланг нэгтгэн үзүүлэлт тус бүрийг 10 хүртэл оноогоор дүгнэж Тэргүүлэгчдэд танилцуулна.

3.3. Тэргүүлэгчид хэлэлцээд хамгийн өндөр оноотой нэг Төлөөлөгчийг “Оны шилдэг Төлөөлөгч”-өөр шалгаруулна.

3.4. Энэхүү журмын 2.4 дахь үзүүлэлтийг сум багаас, 2.10, 2.14-2.16 хүртэлх үзүүлэлтүүдийг холбогдох байгууллагуудаас тус тус санал авч дүгнэнэ.

3.5. Шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар мониторинг, судалгаа хийлгэж болно.

3.6. “Оны шилдэг Төлөөлөгч”-ийг жил бүр шалгаруулан нийтэд зарлан алдаршуулж, Сар шинийн баярын төрийн болон аймгийн шагнал гардуулах ёслол дээр дурсгалын цом, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.